

АЖЛЫН ДААЛГАВАР

ТАВАНТОЛГОЙ ОРДЫН ЦАНХИЙН БАРУУН УУРХАЙН А БАГЦАД ХӨРС ХУУЛАЛТ, НҮҮРС ОЛБОРЛОЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

Гүйцэтгэгч нь батлагдсан зураг төсөл, ажлын төлөвлөгөө, захиалагч талын өгсөн чиглэл, зааварчилгаа болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны стандарт, дүрэм, журам, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгой ордын Цанхийн баруун уурхайн А багцад хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил гүйцэтгэнэ.

3. ХИЙГДЭХ АЖИЛ

3.3. Хөрс хуулалт:

Уурхайн хөрс ухаж ачих, шимт хөрс хуулах, ачих, тээвэрлэх, байршуулах, овоолгын техникийн нөхөн сэргээлт хийж хэлбэршүүлэх, тааз цэвэрлэх, ажлын болон ажлын бус ханын цэвэрлэгээ хийх, үерийн уснаас уурхайг хамгаалах далан, суваг, шуудуу байгуулах, уурхайн шүүрлийн усыг хуримтлуулах, зайлуулах, усан сан байгуулах, зумпф ухах, ус шүүрүүлэлт хийх, талбайн усалгаа, гэрэлтүүлэг хийх, зам засах, нүүрсний овоолгын талбай бэлтгэх, дэвсэлт хийх, мөргөцгийн хажуугийн тогтворжилтийн хяналт, хийх гэх мэт уурхайн олборлолт, уулын ажлын өрнөлттэй холбоотой бүхий л ажлуудыг хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэнэ.

- 3.3.1. Уулын ажлын урьдчилсан төлөвлөгөөг захиалагч талаас 3 сараар нэгтгэж гаргана. Тухайн сарын төлөвлөгөөг сар эхлэхэд захиалагч тал боловсруулж баталсан байна. Гүйцэтгэгч тал нь төлөвлөгөөт сарын техникийн бэлэн байдлыг өмнөх сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.
- 3.3.2. Уурхайн болон овоолго, мөргөцгийн хажуугийн тогтворжилтонд байнгын хяналт, судалгаа хийнэ. Нуралт, гулсалт үүссэн тохиолдолд тухайн хэсгийг аюулгүй болгох, нурсан материалыг шилжүүлэх арга хэмжээ авна. Мөргөцгийн нуралт гулсалтаас шалтгаалах асуудлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна. Хяналт хийх мэргэжлийн багаж, тоног төхөөрөмжтэй байна.
- 3.3.3. Чулуулгийн тогтворжилтоос нь хамааруулан уурхайн ажлын болон ажлын бус догол, мөргөцөгийн налууг 35 болон 45-аас 55 градусаар гаргаж экскаватороор хананы цэвэрлэгээ хийнэ. Хөрсний овоолгын техникийн нөхөн сэргээлт хийх өнцөг 19 градус байна.
- 3.3.4. Уурхайн догол, мөргөцөгийн улыг төлөвлөгдсөн загварчлалын өндөржилтийн түвшингөөс дээш, доош 20см-ийн хэлбэлзэлтэй байлгаж болно. Мөргөцгийн улыг түвшин хэмжигч /Laser level/ ашиглаж хянах. Уурхайд ухалт ачилт хийх экскаватор, ачигч бүр ул талбай тэгшлэх, засах бульдозертэй байна.
- 3.3.5. “Эрдэнэс-Тавантолгой” ХК нь нүүрс олборлолтын үеийн хаягдал, бохирдлыг бууруулах дэвшилтэт технологи нэвтрүүлэхээр зорин ажиллаж байгаа. Гүйцэтгэгч нь уг зорилтыг дэмжин ажиллаж, дэвшилтэт технологиор нүүрс ангилан олборлох нийт талбайн 1/3 хэсгийг захиалагчийн тавьсан шаардлагад нийцүүлэн бэлтгэнэ.
- 3.3.6. Уурхайн хөрсийг Хөрсний 2-р овоолго руу тээвэрлэж байршуулна.
- 3.3.7. Уурхайн бусад багцын бусад хэсэгт уулын ажил гүйцэтгэж буй гэрээт олборлогчийн техникийн бэлэн байдал буурах, уурхайн технологийг алдагдуулахгүй байх зэргээс шалтгаалан захиалагчийн саналаар хөрвүүлэн ажиллуулж болно.
- 3.3.8. Өрөмдлөгийн талбайг паспортын дагуу бэлтгэн хүлээлгэж өгнө.

3.4. Нүүрс олборлолт:

Нүүрсийг мөргөцөгөөс ангилан ухаж ачих, ялгах, тээвэрлэх, байршлуулах, нүүрсний ул, тааз цэвэрлэх, талбайн усалгаа, гэрэлтүүлэг хийх, зам засах, нүүрсний овоолгын талбай бэлтгэх, дэвсэлт хийх, мөргөцгийн хажуугийн тогтворжилтийн хяналт, хийх гэх мэт уурхайн

нүүрс олборлолтод холбоотой бүхий л ажлуудыг хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэнэ.

- 3.4.1. Нүүрс олборлолтын урьдчилсан төлөвлөгөөг захиалагч талаас 3 сараар нэгтгэж гаргана. Тухайн сарын төлөвлөгөөг сар эхлэхэд захиалагч тал боловсруулж баталсан байна.
- 3.4.2. Нүүрсний бүхий л мөргөцөгт тухайн нүүрсний давхаргын тогтоцод уялдсан тоног төхөөрөмжийг оновчтой сонгож ухалт, ачилт болон ангилан ялгалт хийж хаягдал, бохирдлыг хамгийн бага байлгах аргаар олборлолтын ажлыг зохион байгуулна. Нүүрсний давхаргын тааз, ул цэвэрлэх ажлыг бульдозер, экскаватор, автогрейдерээр хийж гүйцэтгэнэ.
- 3.4.3. Нүүрсийг хөрсний овоолгод буулгаж хаясан тохиолдолд захиалагч болон гүйцэтгэгч талаас хамтарсан акт үйлдэж, тухайн нүүрсийг нээхэд хуулсан хөрсний өртөг, хаясан нүүрсийг борлуулах үнээр тооцон уулын ажлын гүйцэтгэлээс хасч тооцно.
- 3.4.4. Уурхайн мөргөцөгөөс 600 мм-ээс ихгүй бөхөллөгтэй нүүрс олборлоно.
- 3.4.5. Нүүрсний овоолгод овор хэтэрсэн нүүрс гарах тохиолдолд бутлаж, жижиглэнэ.
- 3.4.6. Уурхайн нүүрсний мөргөцөг болон нүүрсний овоолгоос чанарын дээж авах ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг ажиллуулна.
- 3.4.7. Нүүрсний овоолгод халалт, уугилт болон гал гарсан үед галын голомтыг тараан хөргөх, таслан ачиж, тусгаарлах, тээвэрлэн зайлуулах, хучих ажлыг хийж гүйцэтгэнэ. Тусгаарлаж хөргөсөн нүүрсийг чанараас нь хамааруулан нүүрсний овоолго болон хөрсний овоолгод шилжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.
- 3.4.8. Ажлын талбай дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс ачилт хийж буй хэсгийн тээврийн зам, ажлын бүс, овоолго бүрт, ажлын талбайн гэрэлтүүлгийг хангалттай хэмжээнд байрлуулна.
- 3.4.9. Нүүрсний овоолгын болон нүүрсний агуулахын зам, нүүрсний овоолгын ул, талбай, нүүрсний овоолго хоорондын зам, хяналтын пүү, орж, гарах пүүний зам, худалдааны тээврийн машины зогсоолын зам, талбайг засах, өргөтгөх, сайжруулах, услах, арчлах ажлуудыг захиалагчийн гаргасан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.
- 3.4.10. Уурхайн бусад багцын бусад хэсэгт уулын ажил гүйцэтгэж буй гэрээт олборлогчийн техникийн бэлэн байдал буурах, уурхайн технологийг алдагдуулахгүй байх зэргээс шалтгаалан захиалагчийн саналаар хөрвүүлэн ажиллуулж болно.

3.5. Инженерийн ажил

Уурхайд шинээр технологийн замын дэвсэлт хийх, нүүрсний агуулахын талбайг өргөтгөх, нүүрс тээврийн зам болон уурхайн маршрутын зам засах, овоолгын техникийн нөхөн сэргээлт хийж хэлбэршүүлэх, үерийн уснаас уурхайг хамгаалах далан, суваг, шуудуу байгуулах, уурхайн шүүрлийн болон гадаргын усыг хуримтлуулах усан сан байгуулах, зумпф ухах, дэвсэлт хийх гэх мэт уурхайн туслах ажлуудыг хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэнэ.

- 3.5.1. Захиалагчийн шаардлагын дагуу гэрээний хавсралтад заасан Уурхайн ерөнхий төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажил нь тухайн сард гүйцэтгэх уулын цулын 1 хувьд ногдох хэмжээний бүтээлийн бус инженерийн ажлыг үнэ төлбөргүйгээр гүйцэтгэнэ. Тухайн сард хийгдээгүй инженерийн ажлыг хуримтлагдсан дүнгээр тухайн жилийн хэмжээнд тооцон тухайн жилдээ хийж болно. Уг ажил нь 1 хувиас хэтэрсэн тохиолдолд Гүйцэтгэгчээс туслах техникийн мот/цагийн үнэлгээг авч, ажилласан мот/цагийн хэмжээг уулын цулд шилжүүлж тооцож төлбөрийг төлөх бөгөөд инженерийн ажил хийсэн гэж бүртгэл хөтөлнө.
- 3.5.2. Гэрээт олборлогчийн хүсэлтийн дагуу хийгдэх засварын талбай, захиргаа, шатахуун түгээх станц гэх мэт инженерийн ажилууд нь ТЭЗҮ-ийн хүрээний дотор, нүүрсний гарш хэсэгт хийгдэх тохиолдолд тухайн ажлыг уулын ажлын бүтээлд тооцохгүй.

3.6. Зам талбай засах, услах:

Уурхайн бүсийн хил доторхи (хавсралт зураг №1-д уурхайн бүсийн хилийг харуулсан) хөрс, нүүрс тээврийн зам, талбайг засах, өргөтгөх, шинээр барих, сайжруулах, услах, арчлах ажлуудыг захиалагчийн гаргасан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.

3.6.1. Уурхайн дотоод тээврийн налуу (траншейн зам) болон хөрсний овоолгын налуу зам, технологийн авто тээврийн замуудад хур тундас орсон үед халтиргаа гулгаа үүсэхээс урьдчилан сэргийлж хайргажуулах, хүйтний улиралд усалгаа хийж болохгүй үед тоос дарах химийн бодис ашиглаж улирлын болон цаг агаарын саатлаас шалтгаалж гардаг сул зогсолтыг багасгах нөхцөл бололцоог бий болгож ажиллана.

3.6.2. Захиалагчаас гаргасан төлөвлөгөө, зураг төслийн хүрээнд нүүрсний агуулахын болон бусад зам талбайд өргөтгөл хийх, шинээр барих, агуулахын талбайн уланд нүүрс дэвсэх ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

3.6.3. Удаан ашиглагдах байнгын налуу зам, гадаргын замд хайрга, дайрга дэвсэж тоосжилт болон хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллана.

3.7. Уурхайн ус таталт, шүүрүүлэлт:

3.7.1. Уурхайн ухаш, бусад байгууламжуудыг гадаргын болон гэнэтийн үерийн уснаас хамгаалах далан, суваг, шуудуу байгуулах, үерийн усны урсах гольдрол, чиглэлийг өөрчлөх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

3.7.2. Уурхайн мөргөцөгт шүүрч орох усыг уурхайн хамгийн доод түвшингээс доош байлгаж шүүрүүлэлт, ус таталт хийнэ.

3.7.3. Уурхайн талбайн гадна төлөвлөгдсөн талбайд мөргөцгөөс шүүрүүлж, насосаар татсан усыг хуримтлуулах стандарт шаардлагад нийцсэн усан сан байгуулна.

3.7.4. Уурхайн дотоод шүүрлийн болон гадаргуугийн хур тунадас, үерийн усыг шийдвэрлэх арга хэмжээг инженерийн ажлаар тооцон ажиллана.

3.7.5. Уурхайн орчинд гадаргын усыг хуримтлуулан ашиглах инженерийн байгууламжийн ажлыг захиалагчийн гаргасан төлөвлөгөөний дагуу хамтран ажиллаж гүйцэтгэнэ.

3.8. Хөрсний овоолго:

3.8.1. Уурхайгаас гарсан хөрсийг Хөрсний 2-р овоолго руу тээвэрлэнэ.

3.8.2. Батлагдсан журам, зураг төсөл, төлөвлөгөөний дагуу үндсэн хөрс, элс хайрганы холимог хөрс (шимэрхэг), шимт хөрсний овоолгууд үүсгэх, хэлбэржүүлэх, зам талбай тэгшлэх, техникийн нөхөн сэргээлт хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.

3.8.3. Хөрсний овоолгын хаагдаж байгаа доголдуудыг хэлбэршүүлж, техникийн нөхөн сэргээлт хийнэ.

3.9. Нүүрсний овоолго:

3.9.1. Батлагдсан журам, зураг төсөл, төлөвлөгөөний дагуу нүүрсний овоолгууд үүсгэх, хэлбэржүүлэх, зам талбай тэгшлэх, ачилтын давцан шинээр үүсгэх ажлуудыг гүйцэтгэнэ.

3.9.2. Захиалагчийн шийдвэрээр олборлосон нүүрсийг чанараар нь ангилан овоолго үүсгэх ба нүүрсний овоолгуудад чанарын холилт хийнэ.

3.9.3. Нүүрсний овоолгод халалт, уугилт гарсан тохиолдолд шатсан нүүрсийг тусгаарлах, шилжүүлэх арга хэмжээ авна.

3.9.4. Нүүрсний овоолгод бохирдолттой нүүрс буулгасан тохиолдолд шаардлагатай цэвэрлэгээг тогтмол хийнэ.

3.10. Байгаль орчин, усны бодлого, орчны хамгаалал, нөхөн сэргээлт:

3.10.1. MNS ISO 14001:2016 Байгаль орчны менежментийн тогтолцооны шаардлагыг биелүүлэх, дагаж мөрдөх

3.10.2. Байгаль орчны үндсэн хэсэг болох эдэлбэр газар, газрын хэвлий, агаар, хөрс, ургамал, ус амьтанд онц ноцтой хохирол учруулсан тохиолдолд БОАЖ-ын сайдын 2010 оны 05 сарын 27-ны өдрийн А-156 дугаар тушаалын хавсралтад заасан байгаль орчны

хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлалын дагуу уурхайн хөрс хуулалт, олборлолтын талбайн экологи-эдийн засгийн үнэлгээ тооцох аргачлалын дагуу нөхөн төлбөр тооцно.

- 3.10.3. Гүйцэтгэгч нь байгаль орчин, усны бодлого хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу гэрээт олборлогчийн хүлээх үүргийг хуваарийн дагуу биелүүлж, биелэлтийг захиалагчид улирал бүр тайлагнана.
- 3.10.4. Шимт хөрсний овоолгыг захиалагчийн дотоод журам болон MNS 5916:2008 стандартын дагуу хуулах, овоолго үүсгэх, зүлэгжүүлэх хамгаалалт хийх ажлуудыг гүйцэтгэнэ. Шимт хөрсний 10.0 га талбай бүхий хэсэгт арчилгааны ажлыг хариуцан гүйцэтгэнэ.
- 3.10.5. Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн хий, хатуу, шингэн хог хаягдлыг Монгол улсын хууль, журам, стандарт болон захиалагчийн дотоод журмын дагуу төвлөрүүлэх, зайлуулах, аюултай хог хаягдлыг устгах буюу саармагжуулах, хог хаягдлын стандарт байгууламжийг барих, дахин боловсруулах үйлдвэрт хүргэх цогц арга хэмжээг тусгасан хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулан захиалагчаар хянуулан батлуулж гэрээт хугацаанд буюу тухайн жилдээ төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллана.
- 3.10.6. Үйл ажиллагааны явцад эвдэрсэн, доройтсон, бохирдсон газар болон хог хаягдлын түр цэгт техникийн нөхөн сэргээлт хийн бохирдлыг арилгаж, ажил дуусгавар болоход захиалагчид хүлээлгэж өгнө.
- 3.10.7. Уурхайн хөрс болон нүүрс тээврийн технологийн дотоод замаас үүсэх тоосжилтын түвшнийг шинжлэх ухааны аргаар хэмжих, дэвшилтэт технологи ашиглан бууруулах төлөвлөгөөг боловсруулан, захиалагчаар батлуулан хэрэгжилтийг сар бүр тайлагнаж ажиллана. Монгол улсын стандарт хэтэрсэн тохиолдолд тусгай зориулалтын бодис ашиглах. Технологийн усны хэрэглээг бууруулах үүднээс зам талбайн усалгаанд зориулалтын бодис, дэвшилтэт технологи ашиглана. Мөн технологийн замуудад хайрга дайргаар дэвсэлт хийнэ.
- 3.10.8. Ажлыг гүйцэтгэх үедээ нийтийн зам талбай, байгууламжид чулуу, шороо, барилгын материалын үлдэгдэл зэрэг хог хаягдал хаяхгүй цэвэр цэмцгэр байлгах, орчин тойрныг бохирдуулахгүй, хаягдсан хог материалыг бүрэн цэвэрлэж, орчны хэвийн нөхцлийг тухайн ажлын өдөрт нь сэргээж, цэвэрлэж байна.
- 3.10.9. Гэрээний дагуу уулын ажилд өртсөн, ашигласан бүхий л газар, талбайд нөхөн сэргээлт хийж захиалагчид хүлээлгэж өгнө.
- 3.10.10. Жил бүр 10,000-с багагүй суулгацыг тариалах.
- 3.10.11. Өмнөговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2015 оны 04 сарын 23-ны өдрийн 56 дугаар тогтоолын “Тонн баялаг – нэг мод” хөтөлбөрийн дагуу жил бүр суулгацийг тариалан усалгаа, арчилгааг хариуцан ажиллаж, гэрээний хугацаа дуусахад захиалагчид хүлээлгэн өгнө.

3.11. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй:

- 3.11.1. Уулын ажлуудыг гүйцэтгэхдээ Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг чанд баримтлан ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, эрүүл ахуйг бүрэн хариуцаж ажиллах бөгөөд холбогдох менежментийн системийг боловсруулан, захиалагчаар батлуулж, гэрээт хугацаанд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана.
- 3.11.2. Уурхайн технологийн ажлуудад зориулан аюулгүй ажиллагааны журам, горим боловсруулан Захиалагч талаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдүүлж ажиллах бөгөөд шаардлагатай эрсдлийн үнэлгээг хийсэн байна. Мөн үйл ажиллагаандаа OSHAS 18001 стандартыг нэвтрүүлж ажиллах бөгөөд шаардлагатай ажлууд дээр дутуу дүрэм журмыг боловсруулан захиалагчаар батлуулж, мөрдөж ажиллана.
- 3.11.3. Ажлын гүйцэтгэлийн явцад гарсан технологийн болон аливаа ажил үйлчилгээний доголдол гарсан тохиолдолд захиалагч талд мэдэгдсний дагуу заасан хугацаанд арга хэмжээ авч, үр дүнг захиалагч талд танилцуулж, зөвшөөрөл авсны дараагаар хэвийн үйл ажиллагааг эхэлнэ.
- 3.11.4. Захиалагч талын инженер техникийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй,

байгаль орчин, усны бодлогын /Цаашид ХАБЭА, БОУБ гэх/ ажилтнуудыг ажлын талбайд зохих журмын дагуу саадгүй нэвтрүүлэх бөгөөд тэдгээр ажилтны холбогдох дүрэм журамд нийцүүлэн тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

- 3.11.5. ХАБЭА, БОУБ-ны талаарх үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамжуулахгүй, давхар гэрээлэхгүй.
- 3.11.6. ХАБЭА, БОУБ-той холбоотой аливаа зөрчил дутагдал гарсан тохиолдолд захиалагч нь зөрчлийг арилгуулах, гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс тодорхой суутгал хийх бүрэн эрхтэй бөгөөд, цаашилбал хүний амь нас, эрүүл мэндэд хохирол үзүүлж болохуйц аюул, эрсдэлтэй нөхцөл аль нэг ажлын байр болон үйл ажиллагаанд үүссэн тохиолдолд ЭТТ компанийн ХАБЭА, БОУБ-хариуцсан албан тушаалтан болон үйлдвэрлэл хариуцсан захирлууд үйл ажиллагааг тодорхойгүй хугацаагаар шууд зогсооно.
- 3.11.7. Гүйцэтгэгч нь үүссэн аюул эрсдэлтэй ажлын байр болон нөхцлийг бүх ажлын байруудад арилгасаны дараа үйл ажиллагааг захиалагчийн зөвшөөрлөөр эхлүүлнэ. Гүйцэтгэгч нь Захиалагчийн зөвшөөрөлгүй буюу засч залруулах арга хэмжээг хангалтгүй авсан үед үйл ажиллагаагаа дур мэдэн эхлүүлсэн эхний тохиолдолд ХАБЭА, БОУБ-ны гүйцэтгэлийг дүгнэх түлхүүр үзүүлэлтийн ХАБ-ын хэсэгт харгалзах хувийг бүхлээр нь; 2 дахь удаа уг зөрчлийг давтан гаргаж үйл ажиллагаагаа Захиалагчийн зөвшөөрөлгүй эхлүүлсэн тохиолдолд тухайн сард төлөх ёстой байсан төлбөрийн ХАБЭА, БОУБ хэсэгт харгалзах хувийг бүхлээр нь шууд хасах; 3 дахь удаа уг зөрчлийг давтан гаргаж үйл ажиллагаагаа Захиалагчийн зөвшөөрөлгүй эхлүүлсэн тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.
- 3.11.8. ХАБЭА, БОУБ-ны гүйцэтгэлийг жил, улирал болон сараар дүгнэх, уг дүгнэлтийг сар бүрийн төлбөртэй хэрхэн уялдуулж тооцоолох Гүйцэтгэлийн Түлхүүр Үзүүлэлтийг гэрээнд нарийвчлан тусгана.

3.12. Уулын ажлын гүйцэтгэх үнэлгээ

- 3.12.1. Уурхайн бүсэд хамаарах (хавсралт зураг №1-д тусгагдсан) уулын цулын ажлыг гүйцэтгэх нэгж үнэлгээг (тэсэлгээгүй уулын цул, 1км хөрс тээвэрлэх) тооцож төгрөг/м³ -ээр ирүүлнэ.
- 3.12.2. Захиалагч нь уулын ажлын гүйцэтгэлийн төлбөрийг гүйцэтгэгч талд төгрөгөөр тооцон бэлнээр болон нүүрсээр төлнө.

3.13. Ажлын даалгаврын хавсралт

- 3.13.1. Хавсралт зургууд:
- Зураг№1. Уурхайн ерөнхий төлөвлөгөө
- 3.13.2. Хавсралт хүснэгтүүд:
- Хүснэгт №2. Уурхайн үндсэн техник, тоног төхөөрөмжүүдийн ажлын үзүүлэлт
 - Хүснэгт №3. Уурхайд ажиллах техник, тоног төхөөрөмжүүдийн жагсаалт

2. ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Ерөнхий:

- 4.3.1. Гүйцэтгэгч нь 3-аас доошгүй жилийн ажлын дадлага, туршлагатай, өмнө нь ижил төрлийн уул уурхайн олборлолтын ажил, үйчилгээ гүйцэтгэж байсан байх.
- 4.3.2. Гүйцэтгэгчийн баг бүрэлдэхүүн нь (Уурхайн уулын ажлыг гүйцэтгэх ажилтнууд нь) ажил үүргээ аюул, осолгүй, технологийн горимын дагуу хэвийн явуулах машин, тоног төхөөрөмж, ажлын багаж, төхөөрөмж хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангагдсан байна.
- 4.3.3. Цаг ашиглалт болон техникийн бэлэн байдлыг 85-аас доошгүй хувьтай байлгана.
- 4.3.4. Гүйцэтгэгч нь олборлож буй нийт нүүрсний тодорхой хэсэгт олборлолтын үеийн хаягдал, бохирдлыг өнөөгийн түвшинээс бууруулах дэвшилтэт технологиор ангилан олборлох үүрэг хүлээнэ.

- 4.3.5. Гэрээний хугацаанд ХАБЭА, БОУБ-ны холбогдолтой хууль, дүрэм, журам зөрчигдсөнөөс үүдэлтэй бүтээлийн алдагдал, цаг хугацаатай холбоотой аливаа хохирлыг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцах чадвартай байх, баталгааг ирүүлэх.
- 4.3.6. ХАБЭА, БОУБ тухай хуулийн дагуу гэрээ байгуулагдсан дариуд Гүйцэтгэгчийн бүх ажилтан ажиллагсад нь өөрийн компанийн аюулгүй ажиллагааны сургалт, зааварчилгаанд бүрэн хамрагдсан, уурхайн талбайд аюулгүй ажиллах ойлголт мэдлэгтэй, түүнийг нотолсон сургалтанд хамрагдсан бүртгэлийн хуудастай байна.
- 4.3.7. Гүйцэтгэгчийн бүх тээврийн хэрэгслүүд болон түүнийг ажиллуулах операторууд тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан байна.
- 4.3.8. Тендерийн ажлыг өгөгдсөн хуваарийн дагуу саадгүй хийж гүйцэтгэхэд шаардлагатай дэд бүтэц, барилга байгууламж, ахуй хангамжтай холбоотой доорх асуудлуудыг бүрэн шийдвэрлэх чадамжтай байх.
- Үүнд:
- 4.3.8.1. 250-аас дээш багтаамжтай ажилчдын кемп буюу ажилчдын сууц, амрах байр, ариун цэврийг хангах орчин, хоол хүнсний агуулах зэрэгтэй байх эсвэл хамтран ажиллах гэрээтэй байх.
 - 4.3.8.2. Техникийн засвар үйлчилгээ хийх стандарт засварын төвтэй байх эсвэл түүнийг барих нарийвчилсан төлөвлөгөөтэй байх.
 - 4.3.8.3. Шатахууны хангалт, нөөцлөлт болон тусгай зөвшөөрөл бүхий компанитай хамтран ажиллах урт хугацааны гэрээтэй байх.
- 4.3.9. Гэрээ байгуулсанаас хойш 30 хоногийн хугацаанд хавсралтад заасан уулын ажлыг хийж гүйцэтгэх хүчин чадалтай техник, тоног төхөөрөмжийг уурхайд бэлэн байлгана. Ажил эхлээгүй хоног болон бүтээл алдахад KPI онооноос хасч тооцно.

2.2. Ажиллах хүч:

- 4.4.1. Гүйцэтгэгч нь хүснэгт №1 болон хавсралт зургуудад заасан уулын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай ажлын баг, ажиллах хүний нөөцөөр бүрэн хангагдсан байна.
- 4.4.2. Багц тус бүрийн ажлын даалгаварын хүснэгт №1 болон хавсралт зургуудад заасан уулын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай ажлын баг, ажиллах хүний нөөцөөр бүрэн хангагдсан байна. Ажиллах багийн ерөнхий танилцуулгыг ирүүлнэ.
- 4.4.3. Аливаа онцгой байдал үүсэх болон гал түймэр гарсан тохиолдолд ашиглах гал унтраах тусгай зориулалтын тоноглогдсон галын машин, холбогдох тоног төхөөрөмж, багаж зэвсэглэмж, тэдгээрийг ажиллуулах эрх бүхий баг бүрэлдэхүүнтэй байна.
- 4.4.4. Аливаа осол аваарын үед эмнэлгийн тусламж үзүүлэх эмч, эмнэлгийн ажилтан, яаралтай тусламжийн нэгжтэй байна.
- 4.4.5. Мэргэжлийн сургалт явуулах эрх бүхий зөвлөх, сургагч багш, сургалтын багтай байна.

2.3. Уулын ажилд ашиглагдах Техник хэрэгсэл, машин механизм:

Гүйцэтгэгч нь хүснэгт №1 болон хавсралт зургуудад заасан уулын ажлыг гүйцэтгэх шаардлагатай техник хэрэгсэл, машин механизмаар бүрэн хангагдсан байна. Уурхайд ажиллах техникүүд нь Liebherr, Caterpillar, Komatsu, Terex, Hitachi, BelAZ зэрэг фирмийн болон түүнтэй дүйцэхүй Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн уул уурхайн техникүүдтэй байна.

2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр гэхэд жилд уулын цулаар 25.0 сая м³ ажил гүйцэтгэх техник, тоног төхөөрөмжийн хослол бэлэн байлгах ба шаардлагатай нотлох баримт болох хөрөнгө оруулалт, үйлдвэрлэгч борлуулалгчтай хамтран ажиллах гэрээ, баримт бичгийг ирүүлэх.

2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр гэхэд жилд уулын цулаар 30.0 сая м³ ажил гүйцэтгэх техник, тоног төхөөрөмжийн хослол бэлэн байлгах ба хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталгаажуулан ирүүлэх.

2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр гэхэд жилд уулын цулаар 40.0 сая м³ ажил гүйцэтгэх техник, тоног төхөөрөмжийн хослол бэлэн байлгах ба хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталгаажуулан ирүүлэх.

2.3.1. Уулын ажлын төлөвлөгөө, зураг төсөл, Уурхайн уулын ажлын горим, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн уулын ажил хийх хангалттай хүчин чадалтай, иж бүрэн үндсэн тоног төхөөрөмжүүдтэй байна. /Жич: Уулын үндсэн үйлдвэрлэл буюу хөрс хуулалт, нүүрс тээвэрлэлтэнд ашиглагдах автосамосвалууд нь уул уурхайн стандартын техникүүд байх ба хойноо давхар тэнхлэгтэй автосамосвалыг зөвшөөрөхгүй.

2.3.2. Гүйцэтгэх этгээд нь үйл ажиллагааны үндсэн машин механизм, тоног төхөөрөмжийн 60% буюу түүнээс дээш хувийг өөрийн эзэмшлийн техник, тоног төхөөрөмжөөр хийж гүйцэтгэнэ. Эдгээр машин механизм, тоног төхөөрөмж нь Монгол улсын нутаг дэвсгэрт бэлэн байх. Тус машин механизм, тоног төхөөрөмжүүд нь Лизингийн болон Фидуцийн гэрээтэй байж болно. /Зураг, танилцуулга, тээврийн хэрэгслийн гэрчилгээ ирүүлэх/

2.3.3. Бусад үндсэн машин механизм, тоног төхөөрөмжийг худалдаж авах тохиолдолд байгуулсан гэрээнд заагдсан дагуу эхний төлбөр төлсөн баримт хавсаргах, ажил эхлэх хугацаа буюу гэрээ байгуулсанаас хойш 60 хоногийн дотор Монгол улсад орж ирэх боломжтой байх./

2.3.4. Үйл ажиллагаанд шаардлагатай үндсэн машин механизм, тоног төхөөрөмж

- 12 м³ буюу түүнээс дээш м³ шанаганы багтаамжтай экскаватор 4 буюу түүнээс дээш байх, Эдгээрийн нийлбэр хүчин чадал нь 60 м³ -ээс багагүй байх
- 6 м³ буюу түүнээс дээш м³ шанаганы багтаамжтай экскаватор 3 буюу дээш байх (Нүүрс олборлолтын ажилд ашиглах)
- 2-4 м³ шанаганы багтаамжтай экскаватор 1 буюу түүнээс дээш байх (Нүүрсний ялгалт, цэвэрлэгээний ажилд ашиглах)
- 100 тн буюу түүнээс дээш тонн даацтай, сард 1,8-1,9 сая м³ хөрс тээвэрлэх хүчин чадал бүхий автосамосвалтай байх. /Автосамосвалын нэгж хүчин чадлыг доорхи өгөгдлөөр тооцоолон үнэлнэ/
- 60 тн буюу түүнээс дээш тонн даацтай автосамосвал 20 буюу түүнээс дээш байх (Нүүрс олборлолтын ажилд ашиглах)

Үйл ажиллагаанд шаардлагатай туслах машин механизм, тоног төхөөрөмж

- 5 м³ -дээш хүчин чадалтай бульдозер – 3 ш,
- 10 м³ -дээш хүчин чадалтай бульдозер – 5 ш байх
- Ажлын цар хүрээнд тохирсон автогрейдер 3 буюу түүнээс дээш байх
- 60 тн буюу түүнээс доошгүй тонн даацтай усалгааны машин 2 буюу түүнээс дээш байх
- Ажлын цар хүрээнд тохирсон Гэрэлтүүлэгч цамхаг 12 буюу түүнээс дээш байх
- Тосолгооны машин 2 буюу түүнээс дээш байх
- 5 тн буюу түүнээс доошгүй тонн даацтай Хог, хаягдлыг тээвэрлэх машин 1 буюу түүнээс дээш байх
- Автокран 1 буюу түүнээс дээш байх
- Дугуй өргөгч 1 буюу түүнээс дээш байх
- Түлшний машин 2 буюу түүнээс дээш байх
- Усны насостой байх
- Галын машин 1 буюу түүнээс дээш байх
- Түргэн тусламжийн машин 1 буюу түүнээс дээш байх

2.3.5. Суурин сүлжээний 3-с багагүй, явуулын /мобайлны/ сүлжээ дамжуулах 5-с доошгүй цамхагтай байх. Тус цамхагууд нь уурхайн бусад багцын бусад хэсэгт ажиллаж буй гэрээт олборлогчийн цамхагуудтай нэгдсэн нэг сүлжээ үүсгэх, өгөгдлүүдийн өргөтгөлөөр тохирон холбогддог байх шаардлагатай.

2.3.6. Уурхайд ажиллах бүх техник, тоног төхөөрөмжүүд нь GPS буюу байрлалын координат дамжуулагч, ээлжийн туршид ажилласан болон сул зогссон төлөвийн мэдээлэл,

- гүйлтийн мэдээлэл, ачигдсан материалын төрөл, жин /даац/, аваарь осол, аюулыг мэдээлэгч, дата баазыг серверт дамжуулдаг, диспетчер лүү шууд холбогддог байх, дээрх мэдээллийг хадгалах, дамжуулахад хүрэлцэхүйх хэмжээний санах ой бүхий хяналт мониторингийн дэлгэцүүд, эх хавтан он боард, сүлжээний тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх шаардлагатай.
- 2.3.7. 2.3.5, 2.3.6-д заасан диспетчер хяналтын системийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг гэрээ байгуулагдсаны дараа Гүйцэтгэгч нь Захиалагчаас өгөгдсөн чиглэлийн дагуу хэрэгжүүлнэ.
- 2.3.8. Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүдийг хөрс хуулалт, нүүрс олборлолт болон бусад талбайд ажиллах байдлаар нь оновчтой хуваарьлалт хийж бүтээлийн болон ажлын мөргөцөг, зам, талбайд тоног төхөөрөмж ажиллуулах, нэвтрүүлэх чадвар, ачааллын нарийвчилсан тооцоолол, схем зургуудыг боловсруулж ирүүлнэ. /Хавсралт хүснэгт №2-ийн дагуу/
- 2.3.9. Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүдийн тоо, бүтээл, ашиглалтанд орсон огноо, техникийн бэлэн байдал зэрэг бусад нарийвчилсан үзүүлэлтүүдийг харуулсан дэлгэрэнгүй жагсаалтыг ирүүлнэ. Жагсаалтанд үзүүлсэн тоног төхөөрөмжүүдийн холбогдох бичиг баримтын хуулбарыг ирүүлнэ. /Хавсралт хүснэгт №3-ийн дагуу/

2.4. Дэд бүтэц, барилга, байгууламж:

Уулын ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай машин техник, тоног төхөөрөмжийг засварлах засварын мэргэжлийн баг бүрэлдэхүүнтэй, зориулалт шаардлагын дагуу тоноглогдсон засвар үйлчилгээний түр төвтэй байх бөгөөд шаардлагатай дэд бүтэцтэй, ажлын байр, ахуй хангамжтай холбоотой асуудлыг стандартын дагуу, бүрэн шийдвэрлэх чадамжтай байна.

3. БУСАД ШААРДЛАГА

- 3.1. Уулын ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай аливаа тусгай зөвшөөрөл авах, сум орон нутагтай гэрээ байгуулах, орон нутгийн засаг захиргаанаас тушаал шийдвэр гаргуулах, газар ус болон түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрөл авах зэрэг асуудлыг Гүйцэтгэгч тал өөрөө хариуцах бөгөөд ийнхүү хийгээгүйгээс гарсан аливаа хохирлыг Захиалагч тал болон бусад талууд хариуцахгүй.
- 3.2. Захиалагчийн шаардлагын дагуу гэрээний хавсралт №1 заасан Уурхайн ерөнхий төлөвлөгөөний зургаас гадуур хийгдсэн ажил нь тухайн сард гүйцэтгэх уулын цулын 1 хувьд ногдох хэмжээний бүтээлийн бус инженерийн ажлыг үнэ төлбөргүйгээр гүйцэтгэнэ. Тухайн сард хийгдээгүй инженерийн ажлыг хуримтлагдсан дүнгээр тухайн жилийн хэмжээнд тооцон тухайн жилдээ хийж болно. Уг ажил нь 1 хувиас хэтэрсэн тохиолдолд Гүйцэтгэгчээс туслах техникийн мот/цагийн үнэлгээг авч, ажилласан мот/цагийн хэмжээг уулын цулд шилжүүлж тооцож төлбөрийг төлөх бөгөөд инженерийн ажил хийсэн гэж бүртгэл хөтөлнө.
- 3.3. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын KPI-г сар бүр үйлдвэрлэл 40 оноо, геологи 20 оноо, технологи 10 оноо, ХАБЭА 20 оноо, байгаль орчин 10 оноогоор дүгнэн үнэлж оноо өгнө. Хасагдах оноо тус бүрийг тухайн сард гүйцэтгэх төлөвлөгөөт ажлын уулын цулын мөнгөн дүнгийн 0.01%-иар үржүүлэн гүйцэтгэгч талд төлөх нийт төлбөрөөс хасч тооцно. 3 сар дараалан KPI онооны нийлбэр 70 хувиас доош орсон тохиолдолд гэрээг цуцлах үндэслэл болно. Дэлгэрэнгүй задаргаар гэрээнд заана.
- 3.4. Цанхийн Баруун уурхайн уулын ажлын технологийн удирдлагыг боловсронгуй болгох, уурхайн хяналт диспетчерийн нэгдсэн системийг захиалагч тал нэвтрүүлэхтэй холбоотойгоор гүйцэтгэгч тал нь хамтран ажиллана. Уурхайн хяналтын системийг ухаж ачих ажил, тээврийн процесс, овоолгын ажилд ашиглана. Үүний тулд гүйцэтгэгч тал нь уулын ажилд ашиглах техник, тоног төхөөрөмжүүдийг 100% удирдлагын системээр хангаж, суурин сүлжээний 3ш болон явуулын сүлжээ дамжуулах 5-с доошгүй цамхагийг уурхайн уулын ажлын байрлал болон сүлжээний радиус буюу тойргийн зайнаас

хамааран оновчтой байрлуулж ашиглана. Цамхаг ашиглах үеийн цахилгааны эх үүсвэрийг гүйцэтгэгч хариуцана. Диспетчер хяналтын систем нэвтрүүлж хэрэгжүүлэн ажиллах тухай албан бичгээр ирүүлнэ.

- 3.5. Уурхайн бусад багцын бусад хэсэгт ажиллаж буй гүйцэтгэгч гэрээт олборлогч компанитай үл маргах, эвлэрэн шийдвэрлэх зарчмыг баримтлан ажиллах, захиалагч болон бусад багцын гүйцэтгэгчидтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллана.
- 3.6. Захиалагч нь Цанхийн баруун уурхайн хөрс хуулалтанд авто-конвейерийн хосолсон тээвэртэй мөчлөг-урсгал технологийн иж бүрдэл нэвтрүүлэн, тээврийн зайг багасган, өртөг зардлыг бууруулахаар ажиллаж байгаа захиалагчийн үйл ажиллагааг Гүйцэтгэгч дэмжин ажиллана.
- 3.7. Гүйцэтгэгч нь Нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлэх талаар Захиалагчаас санал болгосон аливаа ажлыг дэмжин ажиллах.
- 3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай зөвшилцөн орон нутгаас ажиллах хүч авах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллана. Нарийвчилсан заалтыг гэрээ байгуулах үед тусгайлан заана.
- 3.9. Цанхийн Зүүн уурхай, бусад багцын гэрээт олборлогч компанийн техникүүдийг шилжүүлэн оруулах болон Цанхийн зүүн уурхай, бусад багцын гэрээт олборлогч компаниас техникүүдийг шилжүүлэн ажиллуулахгүй байх.
 - 3.9.1. Захиалагч нь урьдчилан мэдэгдсэний дүнд уулын ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, шаардалагатай тохиолдолд уурхайд сул зогсолт хийлгэх эрхтэй. Үүнтэй холбоотой захиалагч талаас ямарваа нэг төлбөрийн хариуцлага хүлээхгүй.
 - 3.9.2. Цанхийн баруун уурхайд ажиллаж буй техник, тоног төхөөрөмжүүд ажлын талбайд багталцахгүй байх, бусад асуудлаас шалтгаалан техникүүд ажиллаагүй тохиолдолд захиалагч тал хариуцахгүй. Үүнтэй холбоотой захиалагч талаас ямарваа нэг төлбөрийн хариуцлага хүлээхгүй.
 - 3.9.3. Давагдашгүй хүчин зүйл (УИХ, Засгийн газрын шийдвэр, Хууль тогтоомжийн өөрчлөлт, ажил хаялт эдийн засгийн хямрал, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гал түймэр, үер усны гамшиг болон бусад байгалийн гамшигт үзэгдэл, гадаад худалдааны хорио цээр болон экспорт, импортын хориг, терроризм, бусад багцын ХАБ-ын зөрчил)-ийн улмаас биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагч тал хариуцахгүй. Үүнтэй холбоотой захиалагч талаас ямарваа нэг төлбөрийн хариуцлага хүлээхгүй.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУВААРЬ

2020 оны хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлын хэмжээ

Хүснэгт №.1.1

Он	Сар	Хөрс хуулалт, м3	Нүүрс олборлолт, тн	Нийт шилжүүлэх цулын хэмжээ, м3
2020 он	1	-	-	-
	2	-	-	-
	3	1,166,667	190,000	1,302,381
	4	1,183,333	190,000	1,319,048
	5	1,183,333	186,667	1,316,667
	6	1,183,333	173,333	1,307,143
	7	1,200,000	180,000	1,328,571
	8	1,216,667	180,000	1,345,238
	9	1,211,905	178,333	1,339,286
	10	1,233,333	201,667	1,377,381
	11	1,233,333	201,667	1,377,381
	12	1,216,667	205,000	1,363,095
Дүн		12,028,571	1,886,667	13,376,190

2021 оны хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлын хэмжээ

Хүснэгт №.1.2

Он	Сар	Хөрс хуулалт, м3	Нүүрс олборлолт, тн	Нийт шилжүүлэх цулын хэмжээ, м3
2021 он	1	2,529,476	304,009	2,746,625
	2	2,529,476	304,009	2,746,625
	3	2,529,476	304,009	2,746,625
	4	2,529,476	304,009	2,746,625
	5	2,529,476	304,009	2,746,625
	6	2,529,476	304,009	2,746,625
	7	2,529,476	304,009	2,746,625
	8	2,529,476	304,009	2,746,625

Он	Сар	Хөрс хуулалт, м3	Нүүрс олборлолт, тн	Нийт шилжүүлэх цулын хэмжээ, м3
	9	2,529,476	304,009	2,746,625
	10	2,529,476	304,009	2,746,625
	11	2,529,476	304,009	2,746,625
	12	2,529,476	304,009	2,746,625
Дүн		30,353,708	3,648,104	32,959,496

2022 оны хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлын хэмжээ

Хүснэгт №1.3

Он	Сар	Хөрс хуулалт, м3	Нүүрс олборлолт, тн	Нийт шилжүүлэх цулын хэмжээ, м3
2022 он	1	2,529,476	304,009	2,746,625
	2	2,529,476	304,009	2,746,625
	3	2,529,476	304,009	2,746,625
	4	2,529,476	304,009	2,746,625
	5	2,529,476	304,009	2,746,625
	6	2,529,476	304,009	2,746,625
	7	2,529,476	304,009	2,746,625
	8	2,529,476	304,009	2,746,625
	9	2,529,476	304,009	2,746,625
	10	2,529,476	304,009	2,746,625
	11	2,529,476	304,009	2,746,625
	12	2,529,476	304,009	2,746,625
Дүн		30,353,708	3,648,104	32,959,496

2023 оны хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлын хэмжээ

Хүснэгт №1.4

Он	Сар	Хөрс хуулалт, м3	Нүүрс олборлолт, тн	Нийт шилжүүлэх цулын хэмжээ, м3
2023 он	1	2,529,476	304,009	2,746,625
	2	2,529,476	304,009	2,746,625
Дүн		5,058,951	608,017	5,493,249

Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдийн ажлын үзүүлэлт

Хүснэгт №2

д	Үзүүлэлт						
	Ажиллах байршил			Хөрс хуулалт	Ул талбайд	Хөрсний овоолгод	Бусад хэсэгт
	Тоног төхөөрөмжийн нэр	Экскаватор	Загвар				
		Авто Самосвал					
		Утгуурт ачигч					
		Бульдозер					
		Автогрейдер					

Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүдийн жагсаалт

Хүснэгт №3

Д	Тоног төхөөрөмжийн нэр			Хүчин чадал багтаамж		Өмчлөлийн хэлбэр	Ашиглалтын хугацаа			Түлш зарцуулалт			Техникийн бэлэн байдал %	Тайлбар
	Төрөл	Загвар	Үйлдвэрлэсэн улс	Нэгж	Хэмжээ		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад өгсөн он	Ашиглалтын хугацаа	Хэмжих нэгж	Нийт ажилласан мот.цаг	Нийт зарцуулсан		
	Экскаватор													
	Автосамосвал													
	Ачигч													
	Бульдозер													
	Грейдер													
	: : : : :													

Жич: Тоног төхөөрөмжүүдийн цаг ашиглалт болон техникийн бэлэн байдлыг 90-ээс доошгүй хувьтай байлгана. Ирүүлсэн жагсаалтын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн техникийн комисс тоног төхөөрөмжүүдийн бэлэн байдлыг шалгана.

